



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын  
хугацаа сунгах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 2 /хоёр/ хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгагдсан хуулийн этгээдүүдтэй гэрээ байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн  
68 тоот тогтоолын  
Хавсралт

Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа  
сунгах хуулийн этгээдийн жагсаалт

| д/д | Хуулийн этгээдийн нэр | Олгосон дугаар | Хугацаа                  | Дугаарлалтын зориулалт                              |
|-----|-----------------------|----------------|--------------------------|---|
| 1   | Энхцовоо ЗБН          | 1800-1904      | 2024.03.31<br>2026.03.31 | Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ |
| 2   | Хүндэт ХХК            | 1900-1900      | 2024.02.07<br>2026.02.07 | Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ |